



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ХЭРЭГЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН СТАТИСТИКИЙН ЧАНАРЫН ТАЙЛАН

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН 2016 ОНЫ
ТООЛЛОГО

Улаанбаатар 2017 он

АГУУЛГА

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	4
2. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	6
3. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ, КОД.....	7
4. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ	12
4.1. Үнэн бодит, найдвартай байдал.....	12
4.2. Цаг хугацаандаа байх, шуурхай байдал	17
4.3. Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байдал	17
4.4. Нийтэд хүртээмжтэй, ил тод байдал.....	18
4.5. Нийцтэй, харьцуулах боломжтой байдал	18
5. НУУЦЛАЛЫГ ХАНГАСАН БАЙДАЛ	18

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНБТ	Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого
ГТЕГ	Гааль, татварын ерөнхий газар
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
УБСЕГ	Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ХАА	Хөдөө аж ахуй
ХК	Хувьцаат компани
ISIC	International standard industrial classification

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-ын тооллого нь манай улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг эрхэлж байгаа ажил, үйлчилгээний чиглэл, байршлаар нь үнэн зөв тогтоож, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг нь бодитойгоор тодорхойлох, эдийн засгийн хөгжлийн түвшинг харуулах, аж ахуйн нэгж, байгууллагын төвлөрөл, байршил, үйл ажиллагааны чиглэлд үндэслэн төр засгийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой.

Мөн ААНБ-ын тооллогоор бизнес регистрийн сангийн үзүүлэлт, дотоодын нийт бүтээгдэхүүн, нөөц ашиглалтын хүснэгт, үндэсний тооцооны данс, хөрөнгө, хөрөнгө оруулалтын статистик мэдээлэл, төрийн бус байгууллагын үйлдвэрлэл, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг тооцоход шаардлагатай үзүүлэлтүүдийг нэлэнхүй ажиглалтаар цуглуулахад чиглэгддэг.

Манай орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр өмч хувьчлал эрчимтэй явагдаж, төрийн өмчийн аж ахуйн нэгжүүд хувьчлагдаж, хувийн өмчийн аж ахуйн нэгж бий болсноос статистикийн мэдээлэл, судалгаанд шинэ арга хэлбэрийг хэрэглэх, ихэвчлэн түүвэр судалгаа, нэг удаагийн тооллого явуулах, төлөөлөгч нэгжийг сонгож, мэдээлэлд хамруулах зэрэг статистикийн шинжлэх ухааны олон аргуудыг ашиглах шаардлагатай болсон.

Иймд, Үндэсний статистикийн хороо нь аж ахуйн нэгж, байгууллагын тооллогыг 1991, 1994, 1998, 2006, 2011, 2016 онуудад улс орон даяар зохион байгуулсан.

Аж ахуйн нэгж, байгууллагын 1991, 1994 оны тооллогод эдийн засгийн үйл ажиллагааны зарим хэсгийг хамруулж, тоолох нэгжийн ажиллагчдын тоонд суурилан хязгаар тавьж, цөөн хэдэн үзүүлэлтийг цуглуулж байсан бол 1998 оноос хойш зохион байгуулсан тооллогод өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж ирсэн.

Мөн тооллогыг зохион байгуулах үеийн улс орны нийгэм, эдийн засгийн байдал төр, засгийн тогтоол, шийдвэртэй уялдан тооллогын асуулгын хуудасны агуулга өөрчлөгдөж ирсэн.

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН 1998 ОНЫ ТООЛЛОГО

Аж ахуйн нэгж, байгууллагын 1998 оны тооллогод бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон

улсын стандарт ангилал (ISIC)-ын 2.0 хувилбарыг нэвтрүүлж, Үндэсний статистикийн газарт бизнес регистрийн санг анх удаа байгуулан, регистрийн сангийн баяжилтыг улирлаар хийх, түүвэр судалгааны хамрах хүрээ болгон ашиглах боломжийг бүрдүүлсэн.

Энэхүү тооллогын үр дүнд регистрийн дугааргүй аж ахуйн нэгж, байгууллага, салбар нэгжүүд нэлээд байгааг илрүүлсэн бөгөөд тэдгээрт шинээр регистрийн дугаар олгуулах ажил хийгдсэн.

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН 2006 ОНЫ ТООЛЛОГО

Аж ахуйн нэгж, байгууллагын 1998 оны тооллогоос хойш аж ахуйн нэгж олноор байгуулагдахаас гадна томоохон компаниуд өөрийн охин компани, салбар нэгжүүдийг байгуулж, өргөжин тэлж, улмаар энэхүү нөхцөл байдалтай уялдан аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн төрөл, үйл ажиллагааны талаарх үнэн бодит мэдээллийг бий болгоход ААНБ-ын тооллого явуулах нөхцөл бүрдэж, ААНБ-ын 2006 оны тооллогыг зохион байгуулсан.

Аж ахуйн нэгж, байгууллагын 1998 оны тооллогын хүрээг орон нутагт төлөөлөгч томилон ажиллуулан тогтоож байсан бол аж ахуйн нэгж, байгууллагын 2006 оны тооллогын хүрээг тогтооход үндсэн гол мэдээллийн эх үүсвэр нь 1998 оны тооллого болон улирал тутам баяжилт хийж ирсэн Бизнес регистрийн сан байлаа.

ААНБ-ын 2006 оны тооллогын үр дүнд Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, төсвийн болон төрийн бус байгууллагаас гадна орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй үйл ажиллагаа эрхлэгчдийг хамруулж, тэдгээрийн үйл ажиллагаанд холбогдолтой бүх талын мэдээллийн санг бүрдүүлсэн.

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН 2011 ОНЫ ТООЛЛОГО

Аж ахуйн нэгж, байгууллагын 2011 оны улсын тооллогод эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилал (ISIC)-ын хамгийн сүүлчийн хувилбар (4.0)-ыг нэвтрүүлж, олон улсын стандартад нийцсэн статистик нэгжийг байгуулах суурийг тавьж, тооллогын үр дүнгээр газар зүйн мэдээллийн санг анх удаагаа бүрдүүлж байснаараа ихээхэн онцлогтой болсон.

Тооллогын асуулгад аж ахуйн нэгж, байгууллагын нийт хөрөнгө, мэдээллийн технологийн холбогдолтой үзүүлэлтийг нэмэлт байдлаар дэлгэрэнгүй оруулсан нь тооллогын мэдээллийн хэрэглээг улам бүр нэмэгдүүлжээ.

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН 2016 ОНЫ ТООЛЛОГО

ААНБ-ын 2016 оны тооллогод уламжлалт цаасан асуулгын хуудасны дагуу мэдээллийг цуглуулдаг байснаас илүүтэйгээр цахим буюу онлайн мэдээллийг бүрдүүлснээрээ ихээхэн ач холбогдолтой болсон.

Мөн ААНБ-ын үйл ажиллагаагаа явуулж байгаа байршлын цэгийг бүрдүүлж, газар зүйн мэдээллийн санг шинэчилсэн.

Тооллогын асуулгад интернэт захиалга авч, үйлчилгээ үзүүлдэг эсэх, байгаль орчныг хамгаалахад зарцуулсан зардал, хөрөнгө оруулалтын мэдээллийг нэмэлт байдлаар цуглуулсан.

2. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого нь ААНБ-ын тоог бодитой гаргаж, статистикийн мэдээлэлд бүрэн хамруулах, тэдний байршил эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл, улс орны эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг тодорхойлох, статистикийн судалгаа, түүвэр ажиглалтын хамрах хүрээг бүрэн тогтооход, тооллогын үр дүн нь улс орны эдийн засгийн бүтэц, хөгжлийн ирээдүйн чиг хандлагыг тодорхойлоход шаардлагатай суурь мэдээлэл болдгоороо ихээхэн ач холбогдолтой.

Хууль, эрх зүйн үндэслэл:

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндэсний статистикийн хороо нь аж ахуйн нэгжийн тооллогыг 5 жил тутам удирдан явуулна” гэж заасны дагуу ААНБ-ын тооллогыг зохион явуулсан.

Түүнчлэн, дараах тогтоол, шийдвэрийг аж ахуйн нэгж, байгууллагын ээлжит тооллого явуулах хууль, эрх зүйн үндэслэл болгосон. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын “Аж ахуйн нэгжийн тооллого явуулах” тухай тогтоол;
- Үндэсний статистикийн хорооны даргын “Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого явуулах үзэл баримтлал, асуулга түүнийг нөхөх заавар батлах” тухай тушаал;
- “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай”, “Компанийн тухай”, “Хоршооны тухай”, “Нөхөрлөлийн тухай”, “Төрийн бус байгууллагын тухай”, “Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай”, “Төр, сүм хийдийн

харилцааны тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай”, “Монголын улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай”, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай”, “Дампуурлын тухай” хууль, эрх зүйн холбогдох актууд.

Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын давтамж, хугацаа:

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойшхи хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагын 5 удаагийн улсын тооллогыг улс орон даяар зохион байгуулсан.

Хамрах хүрээ:

ААНБ-ын тооллогод Үндэсний статистикийн хорооны даргын “Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого явуулах үзэл баримтлал батлах” тухай тушаалд заасан хугацааг үндэслэл болгож, товлосон өдрөөс өмнө үүсгэн байгуулагдсан өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулдаг.

Тооллого явуулах арга:

ААНБ-ын 2016 оны тооллогыг уламжлалт болон бүртгэлд суурилсан аргыг хослуулан явуулсан.

3. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ, КОД

ААНБ-ын 2016 оны тооллогод дараах ойлголт, тодорхойлолт, ангиллыг ашигласан. Үүнд:

Ойлголт, тодорхойлолт:

Үндсэн үйл ажиллагаа: Тухайн нэгжийн борлуулалтын орлогын ихэнх хувийг бүрдүүлж байгаа, “ихээс бага руу хуваарилах” олон улсын дүрмийн дагуух хамгийн дээд түвшний үйл ажиллагааг ойлгоно.

Хоёрдогч үйл ажиллагаа: Үндсэн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааг хоёрдогч үйл ажиллагаа гэж үзнэ.

Борлуулалтын орлого: Бараа, бүтээгдэхүүний өмчлөх эрхийг бусдад төлбөртэйгээр шилжүүлэх, ажил, үйлчилгээг төлбөртэйгээр гүйцэтгэсний орлого юм.

Ажиллагчид: Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг байдал (статус)-д хамрагдаж буй иргэнийг ойлгоно.

Үйл ажиллагаа эрхлэлтийн байдал:

Идэвхтэй нэгж: Тайлант хугацаанд эдийн засгийн хувьд идэвхтэй байсан аж ахуйн нэгж, байгууллагыг ойлгоно. Аж ахуйн нэгж, байгууллага нь эдийн засгийн үйл ажиллагаа явуулахгүй боловч хууль эрхзүй, захиргааны хувьд идэвхтэй байж болно.

Идэвхгүй нэгж: Хуулийн дагуу бүртгэгдсэн боловч эдийн засгийн хувьд үйл ажиллагаа явуулаагүй нэгжийг ойлгоно. Үйл ажиллагаа явуулаагүй шалтгааныг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

Үйл ажиллагаа түр зогссон: 2 жилээс доошгүй хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй боловч цаашид үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг ойлгоно. Хэрэв тухайн аж ахуйн нэгж улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг бол түр зогссон гэж үзэхгүй.

Үйл ажиллагаа бүрэн зогссон: 2 жилээс дээш хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй, тухайн орон нутгийн татварын байгууллагад татан буугдахаар бүртгэгдсэн аж ахуйн нэгжийг ойлгоно. Өөрөөр хэлбэл татан буугдахаар хүлээгдэж байгаа аж ахуйн нэгжүүд орно.

Татан буугдсан: Дампуурсан, хуулийг удаа дараа ноцтой зөрчсөн, үйл ажиллагаагаа явуулах хугацаа дууссан, зорилгодоо хүрсэн учир цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн өөрийнх нь шийдвэр гарсан, нэг ч гишүүнгүй болсон зэрэг үндэслэлээр шүүх татан буулгах шийдвэрийг гаргасан бол татан буугдсан гэж ойлгоно.

Хариуцлагын хэлбэр: Хариуцлагын хэлбэрийг хуулийн этгээдийн бүртгэл хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүртгэлийн мэдээллийн санд үндэслэн дараах ойлголтын дагуу тодорхойлно. Үүнд:

Компани: Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэж ойлгоно. Компани нь хувьцаат, хязгаарлагдмал хариуцлагатай компани гэсэн 2 хэлбэртэй байна /Компанийн тухай хууль, 3-р зүйлийн 1, 4-р заалт/.

Хоршоо: Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн сайн дураараа нэгдсэн, ардчилсан, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэж ойлгоно /Хоршооны тухай хууль, 3-р зүйлийн 1-р заалт/.

Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл: Нөхөрлөлийн хүлээсэн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан эд хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө хамтран хариуцдаг нөхөрлөлийг бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэж ойлгоно /Нөхөрлөлийн тухай хууль, 19-р зүйлийн 1-р заалт/.

Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл: Нөхөрлөлийн хүлээсэн үүргийг наад зах нь нэг гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүрэн хариуцдаг, бусад гишүүд нь гагцхүү нөхөрлөлд оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцдаг нөхөрлөлийг зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэж ойлгоно /Нөхөрлөлийн тухай хууль, 27-р зүйлийн 1-р заалт/.

Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл: Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хоёр, түүнээс дээш иргэн хамтран байгуулах бөгөөд нөхөрлөлийн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан хөрөнгийн хэмжээгээр, нөхөх хариуцлагыг буруутай үйл ажиллагаа явуулсан гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн хөрөнгийн хэмжээгээр бүрэн хариуцна /Нөхөрлөлийн тухай хууль, 29-р зүйлийн 1-р заалт/.

Төрийн бус байгууллага: Иргэд, төрийн байгууллага /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг ойлгоно /Төрийн бус байгууллагын тухай хууль, 4-р зүйлийн 1-р заалт /Жишээлбэл, ашгийн бус нам, эвсэл, сан, мэргэжлийн холбоод, шашны байгууллага зэрэг.

Үүсэн байгуулагдсан хэлбэр:

Нэгдсэн: Компанийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг өөр компанид шилжүүлэхийг ойлгоно /Компанийн тухай хууль, 20-р зүйлийн 1-р заалт/.

Хуваасан: Компанийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим эрх, үүрэг, хариуцлагыг шинээр байгуулагдсан компанид шилжүүлэхийг ойлгоно /Компанийн тухай хууль, 21-р зүйлийн 1-р заалт/.

Тусгаарласан: Компанийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим эрх, үүрэг, хариуцлагыг шинээр байгуулагдсан компанид шилжүүлэхийг ойлгоно /Компанийн тухай хууль, 22-р зүйлийн 1-р заалт/.

Өөрчлөгдсөн: Хувьцаат компани нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани нь хувьцаат компани болох замаар өөрчлөгдөхийг ойлгоно /Компанийн тухай хууль, 23-р зүйлийн 1-р заалт/.

Харьяаллын хэлбэр:

Толгой компани: Өөрийн компанийн гаргасан энгийн хувьцааных нь 51-ээс дээш хувийг шууд буюу шууд бус замаар олж эзэмшсэн компанийг толгой компани гэж ойлгоно.

Охин компани: Компанийн нийт энгийн хувьцааны 50-иас дээш хувийг өөр /толгой/ компани дангаараа эзэмшдэг бие даасан хуулийн этгээдийг ойлгоно /Компанийн тухай хууль, 6-р зүйлийн 3-р заалт/.

Хараат компани: Компанийн нийт энгийн хувьцааны 20-50 хүртэл хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа компанийг ойлгоно /Компанийн тухай хууль, 6-р зүйлийн 1-р заалт/.

Салбар компани: Компанийн салбар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрлах нэгж бөгөөд компанийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь, түүнчлэн төлөөлөгчийн газрын үүргийг гүйцэтгэж болно /Компанийн тухай хууль, 7-р зүйлийн 1-р заалт/.

Төлөөлөгчийн газар: Компанийн оршин байгаа газраас өөр газар байрлах нэгж бөгөөд компанийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулдаг нэгжийг ойлгоно /Компанийн тухай хууль, 7-р зүйлийн 2-р заалт/.

Хоршооны үндсэн үзүүлэлтийн тодорхойлолт:

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ-г зөвхөн хувь нийлүүлсэн гишүүдийн хөрөнгийн хэмжээгээр бичих бөгөөд хандив, тусламжаар нийлүүлэгдсэн хөрөнгийн хэмжээг энд оруулж тооцохгүй.

Нөөцийн сан-д тухайн хоршооны ашгаас 20 хувиар бодож бий болгосон эрсдэлийн сангийн хэмжээг бичнэ.

Тусгай сан-д хоршооны бий болгосон нөөц сангаас бусад сангуудын хөрөнгийн дүнг бичнэ. Тухайлбал, хуваарилагдаагүй орлого, бэлэглэсэн хөрөнгө, хандив, нийгмийн хөгжлийн сан болон тухайн жилийн цэвэр ашиг эдгээр болно.

Хоршооны гишүүдийн тоо нь хоршооны төрлөөс хамааран ялгаатай байна. Тухайлбал, анхан шатны хоршоог 9-өөс доошгүй иргэн, дундын хоршоог 2-оос доошгүй хуулийн этгээд байгуулна.

Хөрөнгө оруулалт: Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хуримтлалыг шинээр буй болгох, түүний техникийн хангамжийг дээшлүүлэн өргөтгөх, сайжруулахад зориулж, тайлант хугацаанд зарцуулсан хөрөнгө, хайгуулын ажлын зардлыг хөрөнгө оруулалт гэж ойлгоно.

Ангилал, код:

Тооллогын үзүүлэлтийн ангилал, кодыг олон улсын зөвлөмж, төрийн захиргааны бусад байгууллагуудын захиргааны мэдээллийн санд мөрдөж буй албан ёсны ангилал, кодтой нийцүүлэн ашигладаг. Үүнд:

- **Монгол Улсын бүсчлэлийн код, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код:** Стандартчилал, хэмжилзүйн газрын 2006 онд гаргасан “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код.
- **Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (5 оронгийн түвшинд):** Сангийн сайдын 2011 оны 04-р сарын 29-ний өдрийн 103 тоот тушаалын 1-р хавсралт.
- **Хариуцлагын хэлбэрийн ангилал:** Компанийн тухай Монгол Улсын хууль, Хоршооны тухай Монгол Улсын хууль, Нөхөрлөлийн тухай Монгол Улсын хууль зэрэг хууль тогтоомжид үндэслэн ангилдаг.
- **Өмчийн хэлбэрийн ангилал:** Компанийн тухай Монгол Улсын хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай Монгол улсын хууль, бусад хууль тогтоомжийг үндэслэн ангилдаг.
- **Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагдсан хэлбэр:** Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу шинээр байгуулагдсан, нийлүүлсэн, нэгдсэн, хуваасан гэж ангилдаг.

- **Төрийн бус байгууллагын чиг үүргийн ангилал:** ҮСХ-ны даргын 2011 оны 04-р сарын 14-ний өдрийн 01/55 тоот тушаалаар батлагдсан ангилал.
- **Эдийн засгийн секторын ангилал:** ҮСХ-ны даргын 2015 оны 02-р сарын 18-ны өдрийн А/26 тоот тушаалаар батлагдсан ангилал.

4. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын чанарын үзүүлэлтийг ҮСХ-ны чанарын баримт бичигт тусгасан дараах шалгуур үзүүлэлтээр тодорхойлов.

4.1. Үнэн бодит, найдвартай байдал

Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогод хамрагдвал зохих ААНБ-ыг хамруулж, мэдээллийг үнэн бодитой, найдвартай байлгах үүднээс дараах зарчмуудыг баримтлан ажиллалаа. Үүнд:

Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд:

- Аж ахуйн нэгж, байгууллагуудыг тооллогод бүрэн хамруулах зорилгоор хамтран ажиллах чиглэл бүхий Сангийн сайд, Хууль зүйн сайдын албан тоот, тушаал, удирдамжийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн.
- ААНБТ-ыг бүрэн хамралттай явуулах, үр дүнг хүлээлгэн өгөх зэрэг тооллогын бүхий л үйл ажиллагааг хамарсан нэгдсэн удирдамжийг боловсруулж, аймаг, нийслэл, орон нутгийн тооллогын комисст хүргүүлж хамтран ажилласан.
- Бизнес регистрийн сан, хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сан, ТЕГ-ын татвар төлөгчийн мэдээллийн санг ашиглан тооллогод хамрагдвал зохих аж ахуйн нэгж, байгууллагын хяналтын тоог тодорхойлж, орон нутгийн тооллогын комисст хүргүүлж, тооллогод ажиллах ажилтнуудын ажлын чиг үүрэг, ачааллыг жигд хуваарилах боломжийг бүрдүүлсэн.
- ААНБТ-ын тусгайлсан цахим хуудсыг боловсруулж, цахим хуудсаар дамжуулан хэрэглэгчдэд ААНБТ-ын талаар мэдээлэл авах боломжийг бүрдүүлж, цахим хуудсанд тооллогын асуулгын хуудас, нөхөх зааврыг монгол, англи, орос, хятад хэл дээр орчуулж, байршуулсан.
- ГТЕГ-т (хуучин нэрээр) албан ёсоор хандаж, аж ахуйн нэгж, байгууллагын татварын тайлан тушаадаг веб сайтад холбосноор тооллогын хамрагдалтыг сайжруулсан.

- ААНБТ-ын үр дүнг газар зүйн мэдээллийн системтэй холбох зорилгоор аймаг, сум, багийн түвшинд ашиглах газрын зургийг нэгдсэн байдлаар хэвлэж, интернетэд холбогдоогүй аймаг, сумдад урьдчилан хүргүүлснээр тооллогын үзүүлэлтийг газарзүйн мэдээллийн системд бүрэн хамруулах боломжтой болсон.
- Тооллогод хамрагдсан эсэхэд хяналт тавих зорилгоор аж ахуйн нэгж, байгууллага бүрт “ТООЛОВ” гэсэн гэрчилгээ цахим болон цаасан хэлбэрээр олгож, баталгаажуулж ажилласан.

Тооллогын явцад:

- ААНБТ-ыг улсын хэмжээнд чанартай, сайн зохион байгуулж явуулах, удирдлагын шуурхай байдлыг хангаж ажиллах зорилгоор аймаг, нийслэлд ҮСХ-ноос бие төлөөлөгчид нэгдсэн удирдамжийн дагуу ажиллаж, тооллогын ажилд мониторинг хийн, зөвлөгөө өгч, холбогдох асуудлыг шийдвэрлэж ажилласан.
- Нийслэлд тооллогыг эрчимжүүлэх зорилгоор Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэгт Нийслэлийн статистикийн газартай хамтран тооллогын явцад өдөр бүр үнэлгээ өгч, санал солилцож, заавар, зөвлөгөө өгч ажилласан.
- ААНБТ-ын явцын мэдээг тооллогын товын хугацаанд 3 хоног тутам, нийт 11 удаа авч, шаардлагатай арга хэмжээ, заавар зөвлөмж өгч байв.
- Нийслэлийн төвийн 6 дүүргийн Бүртгэл, статистикийн газар (хуучин нэрээр)-ын дарга, хэлтэс, тасгийн дарга нар, Нийслэлийн бүртгэл, статистикийн газрын дарга нар оролцсон шуурхай хуралдааныг зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авч ажилласан.
- Тооллогод хамрагдахаас татгалзсан аж ахуйн нэгж, байгууллагад албан тоотыг хүргүүлж, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудтай нь шууд холбогдож, тооллогод хамруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэв.
- Тооллогод Улсын Бүртгэл, статистикийн хуулийн этгээдийн бүртгэлийн тасагт аж ахуйн нэгж байгууллагуудыг тоолох нэмэлт тоологч гаргаж, хурдан шуурхай арга хэмжээ авч ажилласан.
- Тооллогын хамралт, хариултын үнэн, зөв байдлыг сайжруулах зорилгоор тооллогын үеэр хяналт, шалгалтыг тодорхой графикийн дагуу хийх;

Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын ажлыг зохион байгуулахтай холбоотой асуудлаар тоологч, судлаач нарт зориулсан сургалт, семинар, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, сурталчилгаа хийлээ.

Сургалт:

- ААНБТ-ын хоёр шатны сургалтыг дараах агуулгын дагуу зохион байгуулж, статистикийн газар, хэлтсийн 100 гаруй ажилтанг оролцуулсан сургагч багш нарийг сургах эхний шатны сургалтыг тооллого зохион байгуулагдахаас өмнө зохион байгуулсан.
 - Тооллогын ерөнхий асуудал, зохион байгуулалт;
 - 4 төрлийн асуулгын маягт, түүнийг нөхөх заавар;
 - Асуулга үнэн зөвийг шалгах, кодлох;
 - Компьютерт оруулах заавар; онлайн програм, түүнийг ашиглах;
 - Тооллогын газрын зураг;
 - Тоологч, шалгагч нарын үүрэг, баримтлах зарчим, тэдний үйл ажиллагаанд хориглох зүйл.
- Сургагч багш нар орон нутагтаа төрийн сангийн төлөөлөгч нарт 2 дахь шатны сургалтыг зохион байгуулж, нийтдээ 1047 хүн хамрагдсан.

Сурталчилгаа:

- ААНБ-ын тооллогын сурталчилгааг тооллогын бэлтгэл ажлын хүрээнд болон тооллого явагдаж байх хугацаанд аль алинд нь хэвлэл мэдээллийн бүхий л сувгийг ашиглаж, өргөн хүрээтэйгээр явуулсан.
- ААНБТ-ын зорилго, ач холбогдлыг нийтэд ухуулан таниулах ажлыг нарийвчилсан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн. Тухайлбал, тооллогын сурталчилгааг МҮОНРТВ, ТВ-9, ТВ-5, MN-25, UBS, Eagle зэрэг нийт 6 телевиз, Өнөөдөр сонин, Өглөөний сонин, Өдрийн сонин зэрэг 3 сонин, aanb.nso.mn болон e-tax.mta.mn зэрэг албаны болон бусад цахим хуудсаар сарын туршид явуулснаас гадна Мобиком, Скайтел, Жи Мобайл, Юнител зэрэг үүрэн телефоны хэрэглэгчдэд ААНБТ-д хамрагдах тухай уриалгыг тодорхой давтамжтайгаар хүргүүлж байсан.
- Тооллогын явцын талаар болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг тооллогод хамрагдахыг уриалсан мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хийж байв.

- Тооллого явагдах нэг сарын хугацаанд ҮСХ-ны мэргэжилтнүүд аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын онлайн туслах үйлчилгээг үзүүлж, тооллогын талаарх лавлагааг тогтмол өгч ажилласан.
- Орон нутгийн тооллогын комисс сурталчилгааны ажлын төлөвлөгөө боловсруулан орон нутгийн радио, телевизээр болон сурталчилгааны самбар байршуулах зэргээр сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.

Тооллогын баталгаажуулалт: Уламжлалт аргаар тооллогод хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын хувьд тооллогын асуулгын хуудсыг тоологчтой хамтран бөглөсөн албан тушаалтан нэр, гарын үсгээ бичиж, байгууллагынхаа тамгаар баталгаажуулсан. Харин цахим аргаар тооллогод хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын хувьд асуулгыг онлайнаар бөглөж буй албан тушаалтан нэр, албан тушаалаа шивж оруулан байгууллагынхаа байршлыг газрын зурагт тэмдэглэн баталгаажуулалт товчийг дарснаар баталгаажуулалт хийгдсэн.

Хяналт, шалгалт, мониторинг:

ҮСХ-ноос тооллогын мэдээллийн үнэн зөв, найдвартай байдал, хамралтыг сайжруулах, тооллогын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор тооллогын явцад хамралт муу байсан Дархан-Уул, Сэлэнгэ, Сүхбаатар, Хэнтий аймгууд болон Улаанбаатар хотын бүх дүүргүүдэд дараах байдлаар хяналт тавьж ажилласан. Үүнд:

ААНБ-ыг бүрэн хамруулах чиглэлээр:

- ААНТ-ыг зохион байгуулж явуулах аймаг, нийслэлийн тооллогын комиссын үйл ажиллагаатай танилцан, тооллогыг амжилттай, чанартай зохион байгуулахад чиглэгдсэн ажлын нарийвчилсан төлөвлөгөө гарган мөрдөж буй эсэх;
- Тоолох үеийн сурталчилгааны зохион байгуулж буй эсэх;
- УБСЕГ-аас хүргүүлсэн ААНБТ-д хамрагдах нэгжийн жагсаалтын дагуу хамралтыг хянаж, ААНТ-оос хоцорч болзошгүй, олдохгүй байгаа ААНБ-ыг хамруулах чиглэлээр хийгдэж буй ажилд үнэлгээ өгөх, холбогдох арга хэмжээг газар дээр нь шуурхай зохион байгуулах;
- Олон салбартай, олон үйл ажиллагаатай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл бүрийг бүрэн гүйцэд нөхсөн байдалд хяналт тавьсан эсэх;

- Тоологчдоос бүрэн гүйцэд, үнэн зөв нөхөгдсөн асуулгын маягтыг хүлээн авч байгаа эсэх;
- Бүрэн гүйцэд нөхөгдсөн асуулгын хуудсанд алдаа байгаа эсэхийг 10 хүртэл ААНБ-ын асуулгын хуудсыг санамсаргүйгээр сонгож шалгах;
- Тооллогын явцад хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг лавлаж тодруулах, заавар, зөвлөмж өгөх;
- Аймгийн статистикийн хэлтсээс тооллогын мониторинг, хяналт хийж буй эсэх;
- Тооллогын явцын мэдээг графикт хугацаанд дамжуулж буй эсэх;

Тоологчийн үйл ажиллагаа:

- 1-2 тоологчийг сонгон ААНБ-ын жагсаалтын дагуу тооллогод хамрагдах нэгжийг бүрэн хамруулсан эсэхийг шалгах, бүрэн хамрагдаагүй бол шалтгааныг тодруулах;
- Асуулгын хуудасны асуулт, хариултын код бүрийг тоологч хэрхэн ойлгосныг хянах;
- ААНБТ-1 болон ААНБТ-4 асуулгын маягтын уялдааг хэрхэн ойлгож, үнэн зөв нөхсөн эсэх;
- Тооллогод эдийн засгийн үйл ажиллагааны ангиллыг ашиглахтай холбоотой гарч байгаа хүндрэл, бэрхшээлийн талаар асууж лавлан заавар, зөвлөгөө өгөх;
- 1-2 тоологчтой ААНБ-д хамт очиж мэдээлэл цуглуулж буй байдалтай танилцаж, тооллого, судалгааны зорилгыг ААНБ-д үнэн зөв тайлбарлан, асуулгын хуудсыг үнэн зөв нөхөж буй эсэхийг шалгах, заавар, зөвлөмж өгөх;

Тооллогын зардлын зарцуулалт:

- Тооллогод зориулагдсан санхүүжилтийг зориулалтаар нь ашиглаж, баримтуудыг нь үнэн зөв, шаардлагын дагуу бүрдүүлж байгаа эсэх;
- Тоологчдод олгосон томилолт болон тээврийн зардлын баримтыг шалгах, тоологчийн гарын үсэгтэй тулгах;

Тооллогын мэдээллийн чанарын шалгалтыг дараах байдлаар ангилан авч үзэж, шалгалтыг хийсэн. Үүнд:

- Логикийн болон балансын алдаа
- Үзүүлэлт дутуу нөхөх

- Цэг, таслал андуурах
- Хэмжих нэгжийн алдаа
- Ангиллын код буруу оруулах
- Бусад мэдээллийн эх үүсвэрүүдтэй уялдуулан шалгаж, холбогдох тодруулга, засвар өөрчлөлтийг тусгаж, мэдээллийн санг эцэслэсэн
 - Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэл
 - Татварын ерөнхий газрын ААНОАТ-ТТ02 тайлан
 - Нийгмийн даатгалын ерөнхий газрын НД8 тайлан
 - Хөрөнгийн биржийн ХК-ийн бүртгэл
 - Санхүүгийн зохицуулах хорооны даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны тайлан
 - ХАА-н хоршоологчдын холбооны мэдээллийн сангийн үзүүлэлтүүд
 - Сангийн яамны санхүүгийн тайлан баланс
 - Сангийн яамны шилэн данс
 - ҮСХ-ны ААНБ-ын 2015 оны жилийн тайлан
 - ҮСХ-ны Хөрөнгийн хуримтлал, хөрөнгө оруулалтын жилийн эцсийн мэдээ
- Өмнөх тооллогын мэдээллээс хэт зөрүүтэй байгаа эсэх

4.2. Цаг хугацаандаа байх, шуурхай байдал

Цаг хугацаандаа байх байдлыг хангах үүднээс ААНБ-ын тооллогын мэдээллийг компьютерт оруулах онлайн програм хангамжийг боловсруулж ашигласан.

4.3. Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байдал

Хэрэглэгчтэй харилцах менежментийг сайжруулах, эргэх холбоотой ажиллах, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээтэй мэдээллийг судлах, статистик мэдээллийн хэрэглээний түвшинг тодорхойлох үүднээс хэрэглэгчийн бүртгэлийг програмчилсан. Хэрэглэгчдээс гарсан санал, хүсэлтийн дагуу бүтээгдэхүүний

хэлбэр, дизайныг өөрчлөх, нийтэд хүртээмжтэй байх тал дээр байнга анхаарч ажилладаг.

Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын мэдээллийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр тархаадаг ба түүнчлэн хэрэглэгчид албан бичгээр болон өөрийн биеэр хандах, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан мэдээлэл авч байгаа болно.

ААНБ-ын 2016 оны тооллогын үндсэн үр дүнг монгол (http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=AANBT_2016.pdf&ln=Mn), англи (http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=AANBT_eng.pdf&ln=En) хэл дээр боловсруулж, 2018 оны 1 дүгээр сард хэрэглэгчдэд тархаасан болно.

4.4. Нийтэд хүртээмжтэй, ил тод байдал

ҮСХ-ны хувьд бүх хэрэглэгчдийг статистикийн мэдээллээр адил тэгш хангах зарчим баримталдаг бөгөөд хуулийн хүрээнд бүх мэдээлэл хэрэглэгчид нээлттэй, ил тод байдаг хэдий ч аж ахуйн нэгж, байгууллагын тооллогод хамрагдсан нэгжийн мэдээлэл нь нууцад хамаарна.

Иймд аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын мэдээллийг хүснэгтэн, текст, график дүрслэл хэлбэрээр тархаахаас гадна статистик мэдээллийн үйлчилгээний нэгдсэн систем www.1212.mn сайтад байрлуулан нийтэд үнэ төлбөргүйгээр хүргэж байна.

Мөн Үндэсний статистикийн хорооны тооллого, судалгааны каталогт ААНБ-ын тооллогын анхдагч мэдээллийн файл, холбогдох материалын хамт харах боломжтой.

4.5. Нийцтэй, харьцуулах боломжтой байдал

Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогыг таван жилийн давтамжтайгаар зохион байгуулдаг. Иймд урт хугацаанд эдийн засгийн өөрчлөлттэй уялдаж, агуулгын хувьд өөрчлөлт гарч харьцуулагдахуйц байдал зарим талаар алдагдах боловч статистикийн бизнес регистрийн сангийн үндсэн үзүүлэлт болон өмнөх жилүүдийн тооллогын үзүүлэлттэй харьцуулагдах байдлыг хадгалдаг.

5. НУУЦЛАЛЫГ ХАНГАСАН БАЙДАЛ

Монгол улсын “Байгууллагын нууцын тухай”, “Хувь хүний нууцын тухай”, “Статистикийн тухай” хуульд заасны дагуу аж ахуйн нэгжийн тооллогын мэдээлэл нь аж ахуйн нэгж, байгууллагын нууцад хамрагдах бөгөөд тооллогын бүх шатны

ажлын хэсгийн гишүүд ААНБ-ын мэдээллийг бусдад задруулахгүй байх үүрэг хүлээдэг.

Тухайлбал, “Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу албан ёсны статистикийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын ажилтан албан ёсоор мэдээлэх түвшинд хүрээгүй статистикийн мэдээлэл, судалгааны дүн, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нууцад хамаарах мэдээллийг нийтэд задруулахыг хориглоно гэж заасан.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн хорооны ажлын хэсэг тооллогын бүх материалыг нэгтгэж, тооллогын материалын нууцлал, бүрэн бүтэн байдлыг бүрэн хариуцан, арга хэмжээг авч ажилласан.

Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын нууцлалд хамаарагдах материалуудад 1). Аж ахуйн нэгжийн тооллогын нөхөгдсөн асуулга ААН-1; 2). Төрийн бус байгууллагын тооллогын нөхөгдсөн асуулга ААН-2; 3). Төсвийн байгууллагын тооллогын нөхөгдсөн асуулга ААН-3; 4). Аж ахуйн нэгж, байгууллагын байршлыг тэмдэглэсэн болон тэмдэглээгүй газрын зураг багтана.

Тооллогын ажилтнууд нь нууцлалд хамаарагдах дээр дурдсан материалыг хуулбарлах, бусад хувь хүн, байгууллагад мэдээлэх, мэдээллийн нууцыг задруулахыг хатуу хориглосон байдаг.

Тооллогын ажилтнууд аж ахуйн нэгж, байгууллагын талаарх олж авсан мэдээллийн талаар хоорондоо ярилцахгүй байх, гэр бүл, хамаатан садан, найз нөхдөдөө ярихгүй байх, аж ахуйн нэгжийн санхүүгийн мэдээллийг татвар, санхүү гэх мэт бусад төрийн байгууллагын ажилтанд мэдээлэхгүй байх үүрэг хүлээдэг.

Энэхүү чанарын тайлантай холбогдолтой асууж, тодруулах зүйлээ information@nso.mn хаягаар болон 51-261567 утсаар лавлана уу.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР